



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/696

Улаанбаатар хот

Гэр хорооллын дэд бүтцийн газрын  
дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Гэр хорооллын дэд бүтцийн газар”-ын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. ““Гэр хорооллын орон сууцжуулах төсөл” ОНӨҮГ-ын дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/89 дүгээр, “Гэр хорооллын хөгжлийн газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/90 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020003526

## ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр хорооллын дэд бүтцийн газар (цаашид “Газар” гэх) нь Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомж, Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас гэр хорооллыг шинэчлэх талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, холбогдох шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг, үүрэг бүхий нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар тогтоосон журмын дагуу хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.4. Газар нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга, салбар хариуцсан орлогч, Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.

### Хоёр. Газрын үндсэн чиг үүрэг

2.1. Газар дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын газрыг зохион байгуулах, дахин төлөвлөн инженерийн дэд бүтэцтэй амины сууц болон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг иргэдийн оролцоотой зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, төсөлд оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах;

2.1.2. нийслэлийн гэр хорооллыг нийгэм эдийн засаг, экологи, соёл боловсролын тогтвортой хөгжлийг хангасан, суурьшлын бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

2.1.3. гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинээр баригдах амины сууц болон орон сууцны хорооллын инженер хангамжийн шийдлийг бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэх;

2.1.4. гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаанд төрийн захиргааны болон олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтийг татан оролцуулах;



2.1.5.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөр, стандарт, дүрэм, журмын талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

2.1.6.иргэн, аж ахуйн нэгжийн санаачилсан гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн инженерийн дэд бүтцээр хангах хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авч, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн ерөнхий төлөвлөгөөний дагуу шийдвэрлүүлэх;

2.1.7.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний үе шаттай хэрэгжүүлэн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг нийслэлийн төсөвт тусгуулах;

2.1.8.хөрөнгө оруулагч болон бусад байгууллагаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын, санхүүжилтийн саналыг судалж боломжтой тохиолдолд хамтран хэрэгжүүлэх;

2.1.9.хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төслийн ажлын даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах;

2.1.10.инженерийн дэд бүтцээр хангах үйл ажиллагаанд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй шинэ, дэвшилтэт технологийг судлаж, нэвтрүүлэх;

2.1.11.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх инженерийн дэд бүтцийн зураг төсөл болон барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт тавих;

2.1.12.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах иргэн, хуулийн этгээдтэй холбогдох өмчийн эрх зүйн харилцаа, хууль, эрх зүйн бусад асуудлыг хянан судлах, тэдгээрийг зохицуулах талаар санал боловсруулах, иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх;

2.1.13.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу барих барилгын ажлын хугацаанд зайлшгүй шаардлагатай зарим айл өрхийг түр оршин суух байраар хангах ажлыг зохион байгуулах.

### Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1.Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

3.2.Газрын удирдлага нь дарга, орлогч даргаас бүрдэнэ. Газар нь хэлтэс, албатай байна. Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

3.3.Газрын дарга батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлөх бөгөөд орлогч дарга, хэлтэс, албадын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

3.4.Газрын дарга нь хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх болон Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор тушаал гаргаж, дүрэм, журам, бусад шийдвэрийг баталгаажуулан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

3.5. Газар нь эд хөрөнгийн эрхийн байдлаар төсөвт байгууллага байх бөгөөд төсвөөс хуваарилсан хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна. Газрын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг суулгана.



3.6.Газрын дарга холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу батлагдсан төсөвт багтаан ажилтнуудын цалингийн шатлал, шагнал, урамшууллын хэмжээг тогтооно.

3.7.Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

3.8.Газар нь өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, жил улирлын ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын дагуу явуулна.

3.9.Газрын даргын түр эзгүйд түүний зөвшөөрснөөр орлогч дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

3.10.Газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зарим ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

#### Дөрөв. Газрын эрх, үүрэг

4.1.Газар дараахь эрхтэй:

4.1.1.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд иргэд, олон нийт, хувийн хэвшлийн оролцоог хангах;

4.1.2.газрын өмчлөгч, эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч нартай Нийслэлийн Засаг даргаас олгосон эрх хэмжээний хүрээнд гэрээ байгуулж ажиллах;

4.1.3.алслагдсан дүүрэгт өөрийн төлөөлөгч ажиллуулах бөгөөд тухайн нутаг дэвсгэрийг дахин хөгжүүлэхэд оролцох;

4.1.4.нийслэлийн хэмжээнд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн инженерийн дэд бүтцээр хангах хөтөлбөрийн ажилтай холбоотой баримт бичиг, мэдээ, судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах;

4.1.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2.Газар дараахь үүрэгтэй:

4.2.1.нийслэлийн гэр хорооллыг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих;

4.2.2.нийслэлийг хөгжүүлэх эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл, хөтөлбөр, тухайн жилийн санхүүгийн төсвийн төслийг боловсруулахад оролцох;

4.2.3.гэр хорооллыг шинэчлэн хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд төслийн сонгосон талбайг иргэд, хувийн хэвшлийн оролцоотой тодорхойлж, нарийвчилан судлаж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.2.4.Улсын Их Хурал, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад албан байгууллагаас гэр хорооллыг хөгжүүлэх талаар гаргасан шийдвэрийг олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах;

4.2.5. Улсын Их Хурал, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр гарган Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх;

4.2.6. Шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэргүүдийг шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээ, тайланг хагас жил тутам албан бичгээр нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлж ажиллах.

4.2.7. хууль тогтоомжид заасан бусад үүрэг

#### Тав. Хариуцлага

5.1. Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### Зургаа. Бусад зүйл

6.1. Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2. Энэ дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.